

Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн
хуралдааны 2026 оны 07 дугаар сарын 02-ны
өдрийн 67 дугаар тогтоолын хавсралт



Эрүүгийн болон зөрчлийн хэргийн
шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай
хуулийн төсөлд өгөх санал

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцээд дараах саналыг хүргүүлэхээр тогтов.

1. Гүйцэтгэх баримт бичгийн талаар:

Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичигт энэ хуулийн 7.2.5-7.2.9, 7.2.11-т заасан шийдвэрийг үндэслэн шүүхээс олгосон гүйцэтгэх хуудас, энэ хуулийн 7.2.1-7.2.4-т заасан шүүхийн шийдвэр хамаарна” гэж тусгажээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8-д “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана”, 9-д “Шүүх энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан хүсэлтийг ажлын 2 өдрийн дотор шийдвэрлэх бөгөөд хүсэлтийг хангах үндэслэлтэй гэж үзвэл албадан гүйцэтгүүлэхээр гүйцэтгэх хуудас бичнэ” гэж тус тус зааснаас үзвэл эрх бүхий албан тушаалтны шийтгэх хуудсыг албадан биелүүлэх тохиолдолд шүүхээс гүйцэтгэх хуудас бичих ба үүнээс бусад тохиолдолд зөрчлийн хэргийн талаар шүүхээс гарах шийдвэр нь мөн хуулийн 8.2 дугаар зүйлийн 5-д зааснаар шийтгэвэр хэлбэртэй байна.

Гэтэл хуулийн төсөлд зөрчлийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийтгэвэрт гүйцэтгэх хуудас бичигдэхээр зохицуулсан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуультай зөрчилдөнө.

Гүйцэтгэх баримт бичиг гэх ойлголт нь хуулийн төслийн 15, 16 дугаар зүйлийн агуулгаас харахад зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарах бөгөөд үүнд шүүхийн шийтгэвэр, гүйцэтгэх хуудсыг багтаасан атал “Гүйцэтгэх баримт бичгийн агуулга, түүнд тавигдах шаардлага” гэсэн 16 дугаар зүйлд хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрт тодорхой шалгуур, шаардлага тавьж, хангагдаагүй бол шүүхэд буцаахаар, 16.1.5-д эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх баримт бичигт оруулж, 20 дугаар зүйлд зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн бүх шийдвэрт гүйцэтгэх хуудастай байх агуулга илэрхийлсэн нь зүйл хоорондын уялдаа холбоог хангаагүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зохицуулсан хуулиудтай зөрчилтэй байна.

Эрх бүхий албан тушаалтны хуулийн хүчин төгөлдөр болсон шийтгэх хуудсыг албадан биелүүлэх талаар гарсан шүүхийн гүйцэтгэх хуудсаас бусад эрүүгийн болон

зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн шийтгэвэр, тогтоол, магадлал нь хуулийн хүчин төгөлдөр болсон тохиолдолд шууд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болно. Хэрэв шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг ойлгомжгүй, эсхүл техникийн шинжтэй алдаа гарсан бол прокурор, оролцогчдын санал, хүсэлтээр шүүх өөрөө залруулах, тайлбарлах, тодруулахаас бус гүйцэтгэх хуудсаар уг асуудлыг шийдвэрлэхгүйн гадна шүүхээс эрүүгийн хэрэг болон зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх шатанд гаргах эрх зүйн актад гүйцэтгэх хуудас хамаарахгүй гэсэн зарчмын байр суурийг илэрхийлж байна.

2.Хуулийн төслийн 40 дүгээр зүйлд баривчлах байрны шууд зардлыг зөрчил гаргасан хүнээр төлүүлэх агуулгаар зохицуулсан нь төрийн албадлагын мөн чанарыг алдагдуулсан шинжтэй. Өөрөөр хэлбэл, баривчлах шийтгэл нь нийгмийн дэг журмыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд төрөөс албадлага хэрэглэх замаар хүний эрхийн хязгаарлалт тогтоодог атал уг хязгаарлалтыг хэрэгжүүлэхэд гарсан зардлыг төлүүлж буй нь хүний эрхийн зөрчилд хүргэж болзошгүй.

3.Эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хуулийн төслийн 46 дугаар зүйлийн 46.1-т хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн хамт хүлээж авах зохицуулалтыг дэмжихгүй. Учир нь шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээ нь шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болтол үргэлжлэх бөгөөд хэрэв шүүхээс шийтгэх тогтоол гаргасан тохиолдолд хүчин төгөлдөр болсон үеэс таслан сэргийлэх арга хэмжээ дуусгавар болж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхэлнэ. Нөгөө талаар, тухайн хэргийг хянан хэлэлцэж шүүх шийдвэрээ гаргаснаар шүүхийн процесс дуусгавар болдог хуулийн зохицуулалттай тул ял шийтгүүлсэн этгээдийг шийдвэрийн хамт шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргэх нь шүүхийн үүрэг байх боломжгүй.

Эрүүгийн хуулийн 21.17 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй холбогдуулан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцох эсэхийг анхаарах нь зүйтэй.

4.Хуулийн төслийн 53 дугаар зүйлийн 53.1-д “Шүүхээс эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн удирдах албан тушаалтны гадаадад зорчих эрхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох хүртэл түдгэлзүүлнэ” гэж хэт ерөнхий агуулгаар зохицуулсан давхар хариуцлагын шинжтэй байна.

Эрх хасах нэмэгдэл ял эдэлж буй хүний хувьд шүүхийн шийдвэрт заасан хугацаагаар хориглосон үйл ажиллагаа явуулсан эсэхэд хяналт тавих нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго бөгөөд хяналтыг хэрэгжүүлэхдээ шүүхийн шийдвэрээр хязгаарласнаас бусад эрх, эрх чөлөөг хөндөх учиргүй. Мөн нэмэгдэл ялын хугацаанд гадаадад зорчих эрхийг давхар хязгаарлаж буй нь Эрүүгийн хууль үйлчлэх нутаг дэвсгэрийн зарчимд харш болохын зэрэгцээ тухайн ялын зорилго, хүрээ хязгаараас хэтрэх эрсдэлтэй гэж үзэж байна.

5.Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.10-т “Баривчлагдсан хүн нь сэтгэцийн эмгэгтэй, эмнэлгийн хяналтад байдаг, жирэмсэн, 0-3 настай хүүхэдтэй эх, ганц бие эцэг болох нь тогтоогдсон ... тохиолдолд баривчлах байрны захиргаа энэ тухай прокурорт мэдэгдэж, прокурор чөлөөлүүлэх эсэх асуудлыг 72 цагийн дотор шүүхээр шийдвэрлүүлнэ”, 84.7-д “Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авагдсан этгээд гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо бүрэн төлсөн,

шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй тохиолдолд шүүхээс тогтоосон хугацааны 50 хувиас багагүй хугацаа өнгөрсний дараа хугацаанаас нь өмнө хүчингүй болгох саналаа прокурорт гаргаж болно”, 84.8-д “Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 84.7-д заасан санал гараагүй, эсхүл прокурор гаргасан саналыг үндэслэлгүй гэж үзсэн бөгөөд албадлагын арга хэмжээ авагдсан хугацаа дууссаны дараа тухай хүнд ял оногдуулах эсэх асуудлыг шийдвэрлүүлэх саналаа хяналтын хувийн хэргийн хамт прокурорт хүргүүлнэ”, 84.9-д “Энэ хуулийн 84.8-д заасны дагуу гаргасан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл прокурор энэ талаарх дүгнэлтийг шүүхэд хүргүүлнэ” гэж тус тус заажээ.

Эрүүгийн хуульд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хугацаанаас өмнө хүчингүй болгох, эсхүл хугацаа дууссаны дараа ял оногдуулах эсэх, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дууссаны дараа оногдуулсан ялыг эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэхээр заасан боловч тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга, журмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд зохицуулж өгөөгүйн улмаас шүүхээр шийдвэрлэгдээгүй өнөөг хүрсэн. Иймд хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.10, 84 дүгээр зүйлийн 84.7-84.9 дэх хэсэгт заасан зохицуулалтын хүрээнд прокурорын дүгнэлтийг шүүхээр хянан шийдвэрлэх журмыг холбогдох хуульд тусгах шаардлагатай байна.

6.Хуулийн төсөлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэх ажил хариуцсан нэгжтэй байх бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг төслийн 139 дүгээр зүйлд тодорхойлохдоо 139.3.4-д “хоригдол, хоригдсон этгээд, ялтны дундаас урьд үйлдсэн нуугдмал гэмт хэргийг илрүүлэх” гэсэн нь шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэгт хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүний нэгж нь эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүний эсрэг гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглан хорих ангийн аюулгүй байдалтай холбоотой ирээдүйд гарч болзошгүй эрсдэлээс хамгаалах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх бус урьд үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах нь хуулийн зорилго, зорилтод нийцэхгүй тул дээрх зохицуулалтыг дэмжих боломжгүй.

7.Шүүх байгуулах тухай хуулиар гэрлэлт цуцлахтай холбоотой иргэний хэрэг, өсвөр насны хүүхдийн холбогдсон хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийг байгуулж, холбогдох хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг баталсан.

Тухайлбал, өсвөр насны хүнд оногдуулах эрүүгийн хариуцлага нь шийтгэлийн зорилгыг хангахаас гадна хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах үүднээс тухайн хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нь тохирсон амьдрах ухааны дадал олгох мэргэжлийн сургалтын төв ажиллуулах, эрүүл мэндийг хамгаалах, боловсрол эзэмшүүлэх, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, шалгалт өгөх, өөрийгөө хөгжүүлэх дугуйлан, клуб, секцийн үйл ажиллагаанд оролцох, сургалтын орчин, сурах бичгээр хангагдах зэргээр нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хүмүүжлийн үр нөлөөтэй цогц арга хэмжээ байхаар хуульчлагдсан тул хуулийн төсөлд дээрх онцлогийг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай.